

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал
/2021 оны 3 дугаар сар/**


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлж байна.

2021 оны хүйтний улирлын 3 дугаар сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор өөрчлөлтгүй, азотын давхар исэл 11мкг/м³-ээр буюу 24%-иар бага, PM10 тоосонцор 27мкг/м³-ээр буюу 36%-иар, хүхэрлэг хий 31мкг/м³-ээр буюу 76%-иар тус тус их байлаа.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2020 оны 03 дугаар сар	2021 оны 03 дугаар сар
PM2.5 тоосонцор	50	35	34
Азотын давхар исэл, NO ₂	50	45	34
PM10 тоосонцор	100	75	102
Хүхэрлэг хий, SO ₂	50	41	72

Улаанбаатар хотын сүүлийн 5 жилийн хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт харуулав.

PM2.5 тоосонцор




Зураг 1. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2016-2021 он

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 2021 оны 3 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлтгүй, Агаарын чанарын стандарт

MNS 4585:2016 дахь хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-аас хэтрээгүй байна (Зураг 1).


Азотын давхар исэл (NO₂)



Зураг 2. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2016-2021 он

Азотын давхар ислийн 2021 оны 3 дугаар сарын дундаж агууламжийг 2020 оны мөн үетэй харьцуулахад 24%-иар, АЧС дахь ХА-аас тус тус бага байна (Зураг 2).


PM10 тоосонцор



Зураг 3. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2016-2021 он

Агаар дахь PM10 тоосонцрын 2021 оны 3 дугаар сарын дундаж агууламжийг 2020 оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад 36%-иар их, АЧС дахь ХА-ын түвшинд байна (Зураг 3).

Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 4. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2016-2021 он

Агаар дахь хүхэрлэг хийн 2021 оны 3 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 76%-иар их, АЧС дахь ХА-аас 1.4 дахин их байна (Зураг 4).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС